



ЭРЭГТЭЙ
60 НАС



ЭМЭГТЭЙ
55 НАС



НАСАНД ХҮРЭЭД ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ЭРХТЭЙ

Тэтгэвэр тогтоолгох он	Шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа
2024	21 жил 9 сар
2025	22 жил
2026	22 жил 3 сар
2027	22 жил 6 сар
2028	22 жил 9 сар
2029	23 жил
2030	23 жил 3 сар
Жил бүр 3 сараар нэмэгдэн 2037 онд 25 жил болно	



БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- ✓ 1995 оноос өмнө Хөдөлмөрийн дэвтэр
- ✓ 1995 оноос Нийгмийн даатгалын дэвтэр
- ✓ Цэргийн батлах /Эрэгтэй даатгуулагч/
- ✓ 1995 оноос өмнөх 5 жилийн цалин хөлсийг сонгосон тохиолдолд холбогдох архивын лавлагаа эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, тэмдгээр баталгаажсан цалин хөлсний тодорхойлолт
- ✓ Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл
- ✓ Иргэний үнэмлэх
- ✓ Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар /Эмэгтэй даатгуулагч/

ДААТГУУЛАГЧ ШИМТГЭЛ ТӨЛСӨН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХУГАЦААГ ХАНГААГҮЙ БОЛ ТӨРСӨН ОНДОО ХАРГАЛЗАХ НАСАНД ХҮРЭЭД ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ЭРХТЭЙ

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас
1964	61 нас 9 сар
1965	62 нас
1966	62 нас 3 сар
1967	62 нас 6 сар
1968	62 нас 9 сар
1969	63 нас
1970	63 нас 3 сар

Жил бүр 3 сараар нэмэгдэн 1977 он ба түүнээс хойш төрсөн бол 65 настай тэтгэвэр тогтоолгоно

Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас
1969	56 нас 9 сар
1970	57 нас
1971	57 нас 3 сар
1972	57 нас 6 сар
1973	57 нас 9 сар
1974	58 нас
1975	58 нас 3 сар

Жил бүр 3 сараар нэмэгдэн 2002 он ба түүнээс хойш төрсөн бол 65 настай тэтгэвэр тогтоолгоно



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ


НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



“МИНИЙ ТЭТГЭВРИЙН
МӨНГӨН ХУРИМТЛАЛ”-ЫН
талаарх мэдээллээ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
АПЛИКЕЙШН-ЭЭС авна уу!

NDAATGAL 2.0
Хувилбар

ТАНЫ ГАР УТСАНД



ГАР
УТАСНЫХАА



GET IT ON
Google Play



НД-ЫН АПП-АА
ШИНЭЧЛЭЭРЭЙ

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ ЦАЛИН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГООС

Даатгалуулагчийн төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ
Ажил олгогч	8.5
Албан журмын даатгуулагч	8.5
Сайн дурын даатгуулагч	11.5



ӨНДӨР НАСНЫ БҮРЭН ТЭТГЭВЭР АВАХ НӨХЦӨЛҮҮД

1

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2024 оны тухайд 21 жил 9 сар ба түүнээс дээш хугацаанд төлсөн, 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

2

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл, Жишээлбэл, 20 жил шимтгэл төлсөн 1963 онд төрсөн эмэгтэй 56 нас 9 сар хүрсэн бол, 1968 онд төрсөн эрэгтэй 61 нас 9 сар хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

3

Төрүүлсэн болон 3 хүртэл насанд нь үрчлэн авсан 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл өсгөсөн ээж 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол 50 насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

4

Газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд 10-аас доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй 50 насандаа, 7.6-иас доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй 45 насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Гэхдээ нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байна.

5

Хөдөлмөрийн хүнд нөхцөлд 12.6-аас доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй 55 насандаа, 10-аас доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй 50 насандаа тэтгэвэрт гарах боломжтой. Гэхдээ бүгд тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн байх шаардлагатай.

6

Малчин эрэгтэй 55 нас, эмэгтэй 50 настай тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Гэхдээ тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлж, үүнээс эрэгтэйн хувьд 15 жил, эмэгтэйн хувьд 12.6 жилээс доошгүй хугацаанд малчнаар ажиллаж шимтгэл төлсөн байна.



ӨНДАР НАСНЫ ТЭТГЭВРИЙГ ХУВЬ ТЭНЦҮҮЛЭН ТОГТООЛГОХ ЭРХ

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн, төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн даатгуулагч өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй.



ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ТУСГАЙ ЗОХИЦУУЛАЛТ

Нэг гэр бүлийн 2 өндөр насны тэтгэвэр авагчийн аль нь нас барсан тохиолдолд түүний нөхөр эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийг нас барсан тэтгэвэр авагчийн авч байсан тэтгэврийн **20%** хувьтай тэнцүү хэмжээгээр нэмэгдүүлнэ.



Гэр бүл болсноо бүртгүүлж, батлуулсан



20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан

